




Хүчтэй. Хамтдаа.



ЖИЛИЙН ТАЙЛАН **2017**



Агуулга

6	Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлс
8	Гүйцэтгэх захирлын илгээлт
12	Компанийн тухай
13	Товч түүх
15	2017 оны онцлох үйл явдал
16	Хувьцаа эзэмшигчид
17	Компанийн бүтэц, зохион байгуулалт
18	Төлөөлөн Удирдах Зөвлөл
19	Хүний нөөц
22	Бүтээгдэхүүн үйлчилгээ
24	Нийгмийн хариуцлага
27	Харилцагчийн түүх
30	Санхүүгийн гол үзүүлэлтүүд
34	Зээлийн мэдээлэл
40	Эдийн засгийн орчин
44	ББСБ-ын зах зээл
48	Аудитын тайлан
58	Хамтран ажилладаг байгууллагууд



DRAFT

Алсын хараа

Ард Кредит нь санхүүгийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн зах зээлд манлайлж ажиллана.

Эрхэм зорилго

Бид дэвшилтэт технологийг ашиглан Монгол улсад санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, санхүүгийн боловсролыг иргэн бүрт дэлгэрүүлэх зорилготой нийгмийн хариуцлагын тэргүүлэгч байгууллага болно.

Үнэт зүйлс

Сэтгэл ханамжтай баг
Харилцагч төвтэй, шинэлэг үйлчилгээ
Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа
Нийгмийн хариуцлага
Тогтвортой өндөр өгөөж





Гүйцэтгэх захирлын илгээлт

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, хамтран ажиллагсад та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе!

2012 оноос уруудаж эхэлсэн Монгол улсын эдийн засгийн үзүүлэлт 2017 оны гүйцэтгэлээр эргэн өсч 5.1 хувьд хүрсэн бөгөөд гадаад валютын нөөц 2.5 дахин нэмэгдэж 3.2 тэрбум долларт хүрсэн байна. Монгол улсын экспортын голлох хэсгийг бүрдүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өссөнөөр экспортын орлого анх удаа 6 тэрбум долларт хүрсэн бол гадаадын шууд хөрөнгө оруулалт хоёр дахин нэмэгдэж 1.1 тэрбум долларт хүрсэн байна.

Эдийн засаг сэргэж эхлэхтэй зэрэгцээд манай байгууллагын үйл ажиллагаа өмнөх онуудтай харьцуулахад эрс сайжирч, санхүүгийн үзүүлэлтүүд өндөр гарснаас гадна бидний цаашдын хөгжлийн суурь болох системийн шинэчлэлийн ажлууд эхлээд байна. Тайлант хугацаанд манай компанийн нийт хөрөнгийн хэмжээ 79 хувиар өсч 10.2 тэрбум, цэвэр зээлийн багц 60 хувиар өсч 7.8 тэрбум төгрөгт тус тус хүрсэн бөгөөд татварын дараах цэвэр ашиг 640 сая төгрөгт хүрэв. Бид нийт 604 удаагийн

олголтоор 10.8 тэрбум төгрөгийн зээл гаргаж 1.7 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой ажилласан байна. Энэ жил бид өсөлтөө санхүүжүүлэх үүднээс хөрөнгийн зах зээл дээрээс нийт 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг хаалттай өрийн бичиг хэлбэрээр амжилттай босгосон билээ.


Ард Кредит нь нийгмийн хариуцлагаа эрхэмлэдэг байгууллагын хувьд ямагт зээлийн хүүгээ зах зээл дээр өрсөлдөхүйц хэмжээнд барьж ирсэн бөгөөд энэ онд бизнесийн зээлийн хүүгээ 2 хувь хүртэл бууруулж хамгийн бага хүүтэй ББСБ боллоо. Ингэснээр бид харилцагчдынхаа талархлыг хүлээн ажиллахаас гадна зээлийн багцын чанараа сайжруулж чадсан юм. Бид цаашид үйл ажиллагааны болон санхүүжилтийн зардлаа бууруулж, зээлийн хүүгээ байж болох хамгийн бага түвшинд барин ажиллах болно.

Манай компани кредит картны үйлчилгээг олон нийтэд нэвтрүүлсэн анхны ББСБ болов. Бид нийт 416 ширхэг Ард кредит карт гаргасан бөгөөд 2018 оноос эхлэн илүү өргөн цар хүрээнд нэвтрүүлэхээр бэлэн болоод байна. Түүнчлэн бид бэлэн мөнгөний нөөцөө илүү үр дүнтэй удирдах, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрлийг Санхүүгийн

Зохицуулах Хороо(СЗХ)-ноос авсан билээ.

Манай ТУЗ нийт зургаан удаа хуралдаж компанийн стратеги бодлого төлөвлөлтийг тодорхойлон, тайлагналын ил тод байдлыг ханган ажилласан юм. Бид сүүлийн дөрвөн жил дараалан олон улсын нэр хүндтэй компани болох БДО аудитаар санхүүгийн тайландаа шалгалт хийлгэсээр ирлээ. Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-өөс хамгийн том хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болох М.Тулгатыг Ард Кредитийн ТУЗ-ийн гишүүнээр томилох шийдвэр гаргаснаар манай компани засаглалын хувьд улам төгөлдөршиж байна. ТУЗ-өөс 2016 оны ашгийн 50 хувийг ноогдол ашгаар хуваарилах шийдвэр гаргасан нь сүүлийн дөрвөн жилд хоёр дахь удаагийнх болов. Түүнчлэн компанийг IPO хийж олон нийтэд нээлттэй компани болгох ажлыг эхлүүлэх түүхэн шийдвэрийг гаргасан юм.

2018 онд бид дотоод систем, техник технологидоо хөрөнгө оруулалт хийн, компанийн хөгжлийг дараагийн түвшинд гаргах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ингэснээр манай компани Монгол улсын өнцөг булан бүрт салбаргүйгээр хүрч ажиллах бөгөөд эрхэм зорилгоо биелүүлэх боломжтой болох юм.



КОМПАНИЙН ТУХАЙ

2011

• Интергрупп Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдав.

2014

• СЗХ-ны зөвшөөрлөөр анхны хаалттай өрийн бичгээ амжилттай гаргаж нийт 550 сая төгрөгийн санхүүжилт босгов.

• Хувьцаа эзэмшигчдэдээ анхны ноогдол ашгийг хуваарилав.

• Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлэв.

• Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан (БСХС)-тай хамтран ажиллаж, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхүүдэд хөнгөлөлттэй зээл олгож эхлэв.

• Шинэ хөрөнгө оруулалт хийгдэж, шинэ баг бүрэлдэхүүнтэйгээр зах зээл дээр манлайлагч байгууллага болох зорилго тавин ажиллаж эхлэв.

• Эхний хөрөнгө оруулалт амжилттай явагдаж, Ард Санхүүгийн Нэгдлийн 50 хувийн хөрөнгө оруулалттай компани болж, компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оров.

• Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоо (ХБСХДХ)-той хамтарч хөдөө орон нутгийн иргэдэд бичил зээл олгож эхлэв.

2013

2016



- СЗХ-ны шинэ журмын дагуу Хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа эрхлэх төрөлд хамрагдах ББСБ болов.
- Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулга Уулзалтыг зохион байгуулж үндэсний хөрөнгө оруулагчдын хөдөлгөөнийг эхлүүлэв.
- Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 80.7 хувийг эзэмших болов.
- Хувь нийлүүлсэн хөрөнгөө 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн СЗХ-ны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллалаа.
- Худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлэн, 10 гаруй бэлтгэн нийлүүлэгчтэй ажиллаж эхэллээ.

- Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 58 хувийг эзэмших болов.
- БСХС-гаас 500 сая төгрөгийн хөнгөлөлттэй санхүүжилт авч, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 135 айл өрхийн орлогыг нэмэгдүүлэх зээл олгов.

2015

DRAFT



2017

• Онцлох үйл явдлууд

- ББСБ-уудаас салбартаа анхлан Кредит картын бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв.
- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудаас салбартаа хамгийн бага зээлийн хүүтэй байгууллага болон ажиллаж эхэлсэн.
- ГрэйпСити ХХК-тай стратегийн түвшинд хамтран ажиллахаар болж, Поларис үндсэн банкны систем болон Мостмони үйлчилгээг нэвтрүүлэх гэрээ байгууллаа.
- 2017 оны зургадугаар сарын 22-нд СЗХ-ноос Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллав.
- Бид хаалттай хүрээнд компанийн бонд гаргаж хөрөнгийн зах зээл дээрээс 1.7 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлэв.
- “Ард”-ын санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Шангри-Ла Молл салбар үйл ажиллагаагаа амжилттай явуулж эхэллээ.
- Нэгдэл компанийн хамтын ажиллагааны хүрээнд Крипто Үндэстэн Чуулга Уулзалтыг амжилттай зохион байгуулж, криптовалют болон блокчэйн технологийн талаар ард иргэдэд тэгш мэдээлэл өгөх, энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад үйлчилгээгээ танилцуулах боломжийг олгосон юм.

Хувьцаа эзэмшигчид

Ард Санхүүгийн Нэгдэл **80.7%**

В. Баяржаргал **6.6%**



КРЕДИТ
ББСБ

С. Гэрэлтуяа **12.7 %**


Ард Кредит нь нийт гурван хувьцаа эзэмшигчтэй бөгөөд хяналтын багцыг Ард Санхүүгийн Нэгдэл эзэмшдэг юм. Ард Санхүүгийн Нэгдэл нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийнхээ

хөрөнгийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажилладаг үндэсний санхүүгийн нэгдэл компани юм. Ард Санхүүгийн Нэгдлийн бүрэлдэхүүнд Ард Даатгал, Ард Секюритиз, Ард Лайф, Ард Актив, Ард Менежмент, Ард Бит, ТэнГэр Системс, Монгол Шуудан, Номын Хишиг, Жинст Увс (Хөрөнгө Оруулагч Үндэстэн), КриптоҮндэстэн зэрэг компани багтаж байна.

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)-аас компанийн сайн засаглалтай ТУЗ-ийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж ирсэн бөгөөд компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, эрсдэлийг зохистой түвшинд байлгах, компанийн стратеги бодлогыг тодорхойлон удирдан чиглүүлэх, хянах үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Бид олон улсын жишигт нийцэхүйц компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн, ил тод, нээлттэй байдлыг компанийн үйл ажиллагааны бүхий л түвшинд нэвтрүүлсэн жишиг байгууллага болон ажиллаж байна.



ТУЗ-ийн бүрэлдэхүүн



Ч.Ганхуяг
Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Гүйцэтгэх захирал



С.Гэрэлтуяа
Мон Интернэшнл ХХК
Гүйцэтгэх захирал



В.Баяржаргал
ИнтерГрупп ХХК
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал



Б.Ганбат
Техник Технологийн Дээд Сургууль
Гүйцэтгэх захирал



Ч.Ганзориг
Ард Кредит ББСБ ХХК
Гүйцэтгэх захирал



В.Ганзориг
Бат Солюшн Партнерс ХХК
ТУЗ-ийн дарга


Хүний нөөц

Бид тайлант онд нийт 11 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд менежментийн зөвлөх үйлчилгээ болон дотоод аудитыг Ад Санхүүгийн Нэгдэл ХК, Программ хангамж, удирдлагын мэдээллийн системийн үйлчилгээг Тэнгэр системс ХХК, Хуулийн зөвлөх үйлчилгээг Цэц Мэргэн ХХН аутсорсинг хийн хамтарч ажиллалаа.

2017 онд Ард Санхүүгийн Нэгдлийн зүгээс групп компаниудынхаа ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд бид ажиллагсдадаа энгийн хувьцааг урамшуулал хэлбэрээр хуваарилав.

Компанийн хүний нөөцийн бодлогын хүрээнд нийт ажиллагсдыг Ард Даатгал компанийн эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулсан. Мөн, ажиллах хугацаандаа хуримтлал бий болгох, ажлын байрандаа тогтвортой ажиллах, ажил олгогчийн өмнө хүлээх хариуцлагыг нь өндөржүүлэх үүднээс Ард Лайф компанийн тэтгэврийн хуримтлалын санд ажиллагсдаа 100 хувь хамрууллаа.





БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Бид тайлант онд шинээр Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрлийг авснаар дараах зургаан төрлийн үйл ажиллагааг эрхэлж байна.


- Зээл
- Гадаад валютын арилжаа
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх
- Хаалттай өрийн бичиг
- Итгэлцлийн үйлчилгээ
- Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх

Бид тайлант онд зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанар, нэр төрөл, хүртээмжийг сайжруулан, харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх бодлогыг баримталж, бичил зээлийн үйлчилгээнийхээ цар хүрээг хурдацтайгаар өсгөн ажиллав.

Мөн бид зээлийн үйл ажиллагаа эрхлэхдээ зээлдэгчтэй урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааг эрхэмлэх, бичил болон жижиг үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр шинээр бий болгоход зээлийн бодлогыг чиглүүлэн ажилласан байна.


Итгэлцлийн үйлчилгээ

Тайлант онд бид нийт 2,7 тэрбум төгрөгийн итгэлцлийн хөрөнгө татан төвлөрүүлж ажиллав.



Хөдөө орон нутаг

Бид хөдөө орон нутгийн айл өрхүүдэд санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй байдлаар хүргэх, түүнчлэн орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготойгоор 2013 оноос ХБСХДХ-той хамтран ажиллаж, Бөөний зээлийг амжилттай олгож ирсэн юм. Энэхүү хамтын ажиллагаагаа цаашид улам өргөжүүлж, бүх төрлийн бичил санхүүгийн байгууллагад үйлчилдэг Апекс буюу “дээвэр” байгууллага болон хөгжих үндэс суурийг тавин ажиллаж байна. Тайлант онд бид 9 хоршоонд нийт 275 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.



Харилцагчийн түүх



Харилцагч О.Бат-Эрдэнэ

Миний амжилт Ард Кредит ББСБ-тай салшгүй холбоотой


Ард Кредит ББСБ-ын ууган харилцагчдын нэг О.Бат-Эрдэнэ нь анх ахтайгаа хамт бизнесийн гараагаа модны жижиглэн худалдаагаар эхэлжээ. Цаашлаад бизнесийнхээ цар хүрээгээ өргөжүүлэн мах, махан бүтээгдэхүүний худалдааны бизнест хөл тавихаар 2013 онд жижиг, дунд бизнесийн зээлийг Ард Кредит ББСБ-аас авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Түүнээс хойш Бичил бизнесийн зээлийн санхүүжилтээр бизнесээ өргөжүүлэн, Орон нутгаас мах зөөвөрлөх зориулалттай ачааны хоёр автомашин, Улаанбаатар хотод мах хөргүүрийн системтэй нэг агуулах, Жуков худалдааны төв дээр мах, махан бүтээгдэхүүн борлуулах худалдааны таван цэгтэй болжээ.

Тэрбээр “Миний амжилтын үндэс бол Ард Кредиттэй салшгүй холбоотой. Бизнесийг минь өргөжүүлэн тусалж дэмжсэн тус байгууллагын хамт олонд талархаж явдаг. Би бизнесээ өргөжүүлэн өөрийн амьдралаас гадна таван ажлын байр бий болгон таван өрхийг орлоготой болгоод байгаадаа сэтгэл хангалуун явдаг” хэмээн онцолсон юм.

Мөн цаашид ч Ард Кредит ББСБ-ын Бичил болон Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан төслийн зээлд хамрагдан гэр бүлийн энэхүү бизнесээ өргөжүүлж бууз, баншны жижиг үйлдвэртэй болохоор ажиллаж байгаагаа дурдсан юм.

Ард Кредит карт






Нийгмийн хариуцлага

- Бид тайлант онд ББСБХ-ноос санаачилсан “1000 цүнх” аянд амжилттай хамтран оролцож Сонсголын бэрхшээлтэй тусгай 29 дүгээр сургуулийн сурагчдад хоёр дахь жилдээ хичээлийн хэрэгсэл бэлэглэв.
- Цахим хувьсгал буюу цахим мөнгөний хөгжил, криптовалютын зах зээл болон блокчэйн технологийг судлах, эрх зүйн орчинг сайжруулах, ойлголтыг олон түмэнд хүргэх, боловсон хүчин бэлтгэх, зах зээлд криптовалютыг амжилттай нэвтрүүлэх зорилготой Кripto Үндэстэн Чуулга Уулзалтыг зохион байгуулахад оролцож, спонсороор ажиллав.
- 2013 оноос ХБСХДХ-той хамтран ажиллаж, нэмэлт санхүүжилт болон сургалт, зөвлөгөө өгч, гүйцэтгэх захирлын сургалт, уулзалтуудыг зохион байгуулсан байна.
- “Дуулиан 2020” хүүхэд багачуудын хөл бөмбөгийн тэмцээнийг 2014 оноос хойш 4 дэх жилдээ ивээн тэтгэж байна.
- Хүндийг өргөлтийн паралимпын тамирчин Э.Содномпилжээг 2014 оноос хойш ивээн тэтгэж ажиллаж ирсэн билээ. Содномпилжээ нь 2014 онд Сөүлд болсон Азийн наадмаас хүрэл медаль, 2015 онд Дубайд болсон Дэлхийн цомоос мөнгөн медаль, 2016 онд Бразилд болсон Паралимпоос хүрэл медаль, 2017 онд Мексик улсад болсон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медалуудыг тус тус эх орондоо авчраад байна.
- Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафон”-д манай хамт олон идэвхитэй оролцож ирэв.
- Монгол Коосэн Технологийн Ахлах сургуулийн “Монгол Коосэн Робокон” багийг “Эй Би Юу Робокон 2017” тэмцээнд эвээн тэтгэж амжилттай оролцлоо.






САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Голлох тоон үзүүлэлтүүд


Нийт хөрөнгө




Зээл олголтын хэмжээ




Зээлийн багц




Өөрийн хөрөнгө



Татварын дараах цэвэр ашиг



Өөрийн хөрөнгийн өгөөж



Харьцаа үзүүлэлт

	2015	2016	2017
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж	24.7%	19.5%	19.6%
Өр төлбөр/өөрийн хөрөнгө	145.9%	72.8%	172.9%
Зээлийн багц/нийт хөрөнгө	76.9%	85.5%	76.5%
Хуагцаа хэтрэлт 0<хоног	8.5%	6.9%	5.5%
Эрсдэл даах чадвар	51.5%	95.0%	51.7%
Үйл ажиллагааны зардал/дундаж зээлийн багц	13.5%	11.3%	9.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	24.2%	9.7%	22.3%



ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Зээлийн мэдээлэл

Өмнөх оны эдийн засаг, бизнесийн таагүй орчинтой харьцуулахад 2017 оны хувьд эдийн засаг сэргэж, Банк бус санхүүгийн салбарын зах зээл дэх зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт сайжирч эхэлсэн юм.


Тайлант жилд бид зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанар, нэр төрөл, хүртээмж, харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллав. Үүний үр дүнд өнгөрсөн оны сүүлээр шинээр гаргасан Ард кредит картын зээлээ олон нийтэд нээлттэй олгосноор харилцагчдын маань сэтгэл ханамж, эрэлт хэрэгцээ нэмэгдэж, нийт карт эзэмшигчдийн тоо 416-д хүрлээ. Мөн шинээр орон сууц, автомашин, гар утас худалдан авахад зориулсан худалдан авалтын зээл болон хэрэглээний зээлийн нэр төрлөө нэмэгдүүлж, зарим харилцагчдадаа хүргэж ажиллаа.

Ард Кредит ББСБ нь 2017 онд 604 иргэн, ААН-д нийт 10.8 тэрбум төгрөгийн цэвэр зээл олгосон бөгөөд зээлийн багц 7.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхтой харьцуулбал олгосон зээлийн хэмжээ 95 хувиар, зээлийн багц 56 хувиар тус тус өссөн байна. Идэвхтэй зээлийн тоо 57 хувиар өсч, зээлийн дундаж хэмжээ 13.3 сая төгрөг боллоо.

Зах зээл дэх ББСБ-уудаас хүүгийн хувьд өрсөлдөхүйц байж, нэр хүнд, байр сууриа өсгөх бодлогын хүрээнд 2017 оны 5 болон 10 дугаар сард тус тус зээлийн хүүг бууруулж, зээлийн бүтээгдэхүүний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулж ажилласнаар хамгийн бага хүүтэй ББСБ болж, зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2.36 хувьд хүрч, ББСБ-ын салбарын дундаж хүүтэй харьцуулахад зөрүү нь 1 хувь байна.

Тайлант хугацаанд олгосон нийт зээлийн 54 хувийг бичил болон жижиг, дунд бизнесийн зээлийн зориулалтаар, 23 хувийг хэрэглээний зээлд тус тус олгосон байна.

Нийт зээлийн багцыг салбараар авч үзвэл өнгөрсөн жил хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт шинээр зээл олгосон төдийгүй үйлчилгээний салбар дэх зээлийн багцын эзлэх хувь хэмжээ өндөр үзүүлэлттэй байна.





Бүтээгдэхүүний төрлөөр

- | | |
|-----------------|-------------------------------|
| 2% төслийн зээл | 14% хэрэглээний зээл |
| 6% бичил зээл | 29% шуурхай зээл |
| 7% кредит карт | 42% жижиг дунд бизнесийн зээл |

Зээлийн тоогоор


- | | |
|--------------------------|---------------------------|
| 76% 30 сая төгрөг хүртэл | 24% 30 сая төгрөгөөс дээш |
|--------------------------|---------------------------|




Төслийн зээлийн багц

- | | |
|-----------|----------------|
| 4% УБ хот | 96% Орон нутаг |
|-----------|----------------|


Нийт зээлийн багц




Зээлийн тоо



Зээлийн зориулалт (салбараар)



Хугацаа хэтрэлт




Зээлийн эрсдэлийн удирдлага

СЗХ болон ТУЗ-өөс тогтоосон зээлийн эрсдэлийн хязгааруудыг хангаж ажиллахын сацуу зээлдэгчийнхээ тоог өсгөж, зээлийнхээ дундаж хэмжээг бууруулах, зээл олгох салбараа нэмэгдүүлэх зэргээр зээлийн багцын төвлөрөлд хяналттай ажиллалаа. 2017 онд нэгээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн эрсдэлтэй зээлийн нийт багцад эзлэх хувь 5.5 байгаа нь өмнөх оныхоос 1.4 хувиар буурсан үзүүлэлт юм.



ARD App



ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Эдийн Засгийн Орчин

2016 онд эдийн засгийн өсөлт -1.2 хувьтай гарч байсан бол 2017 онд 5.1 хувийн өсөлттэй гарлаа. Энэхүү өсөлтийг салбаруудаар нь авч үзвэл, хөдөө аж ахуй 4.4 хувь, үйлчилгээ 8.5 хувиар өсөв. Мөн 2017 оны хувьд Монгол Улсын экспортын хэмжээ анх удаа 6.2 тэрбум долларыг давж, гадаад худалдааны тэнцэл 1.9 тэрбум долларын ашигтай гарлаа.


Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 23.7 хувиар өсч, зарлага 5.7 хувиар буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1741 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Энэ нь өнгөрсөн сараас 761 тэрбумаар нэмэгдсэн үзүүлэлт юм. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 52.5 хувь буурсан үзүүлэлттэй байна.

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 12-р сард өмнөх сараас 0.5 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, орон сууц, ус, цахилгаан үнэ хамгийн их өссөн байна.


Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өнгөрсөн онд 1.2 тэрбум долларт, алтны худалдан авалт 20 тоннд тус тус хүрч хандивлагч орнууд болон олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр төлбөрийн тэнцэл нэг тэрбум долларыг давж ашигтай гарлаа. Үүний үр нөлөөгөөр гадаад валютын нөөц 3 тэрбум долларт хүрэв.

Засгийн газраас хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах, хууль тогтоомжийг олон улсынхтай нийцүүлэх зорилгоор татварын хоёр дахь шатны шинэчлэлийг хийхээр шийдвэрлэсэн. Жижиг, дунд бизнесийг дэмжихдээ 50 сая хүртэлх орлогоос 1 хувийн татвар авах, мөн аж ахуйн нэгжийн 25 хувийн орлогын албан татварын 3 тэрбум төгрөгийн босгыг 6 тэрбум төгрөгт хүргэхээр ажиллаж байна.


Эх сурвалж Өрсөлдөх чадварын судалгааны төв



**Гадаад
худалдаа**



**Улсын
төсөв**



ДНБ

5.1%



ИНФЛЯЦИ

6.9%



**Төгрөгийн
ам.доллартай
харьцах ханш**

2425.77


төгрөг



**Гадаад
худалдаа**

62.7

сая ам.доллар



ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

ББСБ-ын зах зээл

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын тоо 2017 оны жилийн эцэст 534 хүрлээ. Энэ нь өмнөх оноос 3.09 хувиар өссөн үзүүлэлт юм. Сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр ББСБ-уудын тооны өсөлт хамгийн бага буюу 3.09%-ийн өсөлттэй гарсан нь хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлсэнтэй холбоотой бөгөөд ББСБ-ууд тооноос чанарт шилжих шат руугаа явж байна.

ББСБ-уудын төвлөрлөөр авч үзвэл 464 ББСБ Улаанбаатар хотод, 70 ББСБ хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.


ББСБ-уудын нийт актив 969.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 182.0 тэрбум төгрөгөөр буюу 23.12 хувиар өссөн байна. Энэ нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.37 хувьтай тэнцэж байгаа нь өмнөх оноос 0.27 хувиар өсжээ. ББСБ-уудын активын төвлөрлийг харвал 1.0 тэрбумаас доош хөрөнгөтэй 263 ББСБ нийт активын 15.2 хувийг, 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 241 ББСБ, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 30 ББСБ байгаа буюу эдгээр 271 ББСБ нь нийт активын 84.8 хувийг бүрдүүлж байна.

ББСБ-уудын нийт хөрөнгийн 78.2 хувийг өөрийн хөрөнгө, 21.8 хувийг өр төлбөр бүрдүүлж байгаа нь өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулдаг онцлогтой холбоотой юм.


2017 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 195.9 тэрбум төгрөгийн орлоготой, 129.1 тэрбум төгрөгийн зарлагатай 66.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарлаа.


2017 оны жилийн эцсийн байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 482 ББСБ байгаа ба олгосон зээлийн дээд хүү нь 10%, доод хүү нь 1.16%, жигнэсэн дундаж хүү 3.37% байна. ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.37%-тай гарсан нь 2016 онтой харьцуулахад 0.63 пунктээр буусан үзүүлэлт юм. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 1.8 пунктээр өндөр гарсан байна.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах хороо



Олгосон зээл
Төлөгдсөн зээл





АУДИТЫН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АРД КРЕДИТ ББСБ” ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Ард Кредит ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Ард Кредит ББСБ” ХХК -ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн

дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



**2018 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 16-НЫ ӨДӨР**

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)			
Үзүүлэлт	Тодруулга	2017.12.31.	2016.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5.1	1,095,274.2	233,178.7
Бусдад олгосон зээл, зээлийн хүүний авлага (цэвэр)	5.2	8,023,702.5	5,056,130.3
Богино хугацаат хөрөнгө оруулалт	5.3	28,000.0	5,000.0
Бусад санхүүгийн хөрөнгө	5.4	495,050.2	11,190.3
Бусад хөрөнгө	5.6, 5.7	312,019.9	150,620.8
Эргэлтийн хөрөнгийн дүн		9,954,046.8	5,456,120.1
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	5.8	237,845.5	233,817.3
Биет бус хөрөнгө (цэвэр)	5.9	1,443.3	2,723.3
Урт хугацаат хөрөнгө оруулалт			
Хойшлогдсон татварын хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		239,288.8	236,540.6
НИЙТ ХӨРӨНГӨ		10,193,335.6	5,692,660.7
ӨР ТӨЛБӨР			

Богино хугацаат өр төлбөр			
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	5.5	1,068,255.6	390,000.0
Бусад эх үүсвэр	5.5	4,402,298.8	1,638,127.8
Хуримтлуулж тооцсон хүүний өр төлбөр	5.5	352,465.4	96,343.0
Бусад санхүүгийн өр төлбөр	5.5	22,204.9	2,746.9
Татвар шимтгэлийн өр төлбөр	5.10	55,873.2	27,422.2
Богино хугацаат өр төлбөрийн дүн		5,901,097.9	2,154,640.0
Урт хугацаат өр төлбөр			
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	5.5	552,881.4	240,232.9
Хойшлогдсон татварын өглөг	5.10	4,018.8	4,207.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн		556,900.2	244,439.9
Нийт өр төлбөр		6,457,998.1	2,399,079.9
Өөрийн хөрөнгө			
Энгийн хувьцаа	5.11	1,312,500.0	1,312,500.0
Нэмж төлөгдсөн капитал	5.11	787,500.0	787,500.0
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц сан			
Хуримтлагдсан үр дүн	5.11	1,635,337.5	1,193,580.8
Нийт өөрийн хөрөнгө		3,735,337.5	3,293,580.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		10,193,335.6	5,692,660.7

ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2017.12.31.	2016.12.31
Хүүний орлого	5.12	1,766,868.6	1,363,843.6
Хүүний зардал	5.13	(656,439.6)	(358,440.7)
Цэвэр хүүний орлого		1,110,429.0	1,005,402.9
Гадаад валют арилжааны орлого	5.19	908.5	1,981.4
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз	5.19	87,807.0	288,197.3
Үйлчилгээний орлого	5.14	91,190.5	37,243.4
Гадаад валют арилжааны зардал	5.19	(1,864.0)	(3,924.5)
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн гарз	5.19	(85,347.8)	(261,473.3)
Боловсон хүчинтэй холбоотой зардал	5.15	(310,032.9)	(277,744.6)
Үйл ажиллагааны бусад зардал	5.16	(400,430.6)	(228,124.9)
Цэвэр хүүгийн бус орлого, зардал		492,659.7	561,557.7
Эрсдэлийн сангийн зардал	5.17	(140,590.7)	(154,102.2)
Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал		352,069.0	407,455.5
Үйл ажиллагааны бус орлого	5.18	393,307.3	88,665.9
Үйл ажиллагааны бус зардал	5.18	(31,431.8)	(42,415.3)
Татварын өмнөх ашиг, (алдагдал)		713,944.5	453,706.1
Орлогын албан татварын зардал	5.20	(72,187.7)	(51,942.2)
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)		641,756.7	401,763.9
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	5.21	49	39

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.0	100,000.0	791,817.0	1,891,817.0
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				
Залруулагдсан үлдэгдэл	1,000,000.0	100,000.0	791,817.0	1,891,817.0
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)			401,763.9	401,763.9
Дахин үнэлгээний нэмэгдлийн өсөлт, (бууралт)				
Хувьцаат капиталын өсөлт, бууралт	312,500.0	687,500.0		1,000,000.0
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,193,580.9	3,293,580.9
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				
Залруулагдсан үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,193,580.9	3,293,580.9
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)			641,756.7	641,756.7
Зарласан ногдол ашиг			(200,000.0)	(200,000.0)
Хувьцаат капиталын өсөлт, бууралт				
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,635,337.5	3,735,337.5

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2017 оны 12-р сарын 31-ний өдөр

	(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт	2017.12.31.	2016.12.31.
1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг, (алдагдал)	713,944.3	453,706.0
Тохируулга:		
Элэгдэл, хорогдлын зардал	28,507.5	22,758.0
Авлагын эрсдэлийн сангийн зардал	7,822.9	22,624.0
Үндсэн хөрөнгө акталсны гарз (олз)	(16,605.5)	(71,280.0)
Зээлийн эрсдэлийн сангийн зардал	132,767.8	131,478.0
Ажлын капиталын өөрчлөлт		
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3 сараас дээш хугацаатай)		30,000.0
Зээл ба урьдчилгааны өөрчлөлт	(2,928,026.7)	(1,420,414.0)
Бусад санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт	(491,682.9)	21,356.0
Бусад санхүүгийн бус хөрөнгийн өөрчлөлт	(34,363.5)	7,805.0
Өмчлөх бус үл хөдлөх хөрөнгийн өөрчлөлт	(126,304.9)	(97,600.0)
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөрийн өөрчлөлт		709,591.0
Бусад санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт	(17,987.8)	74,667.0
Санхүүгийн бус өр төлбөрийн өөрчлөлт	22,051.6	1,554.0
Төлсөн орлогын албан татвар	(61,650.6)	(49,044.0)
Хүүгийн орлого /цэвэр/	(1,951,165.1)	(1,363,844.0)
Хүлээн авсан хүү	1,911,619.6	1,329,787.0
Хүүгийн зардал	656,439.7	358,441.0
Төлсөн хүү	(409,185.3)	(318,531.0)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,563,818.9)	(156,946.0)

2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(110,239.0)	(425,217.0)
Худалдсан үндсэн хөрөнгө	16,000.0	
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө	(1,090,620.9)	
Худалдсан санхүүгийн хөрөнгө	1,151,211.4	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(33,648.5)	(425,217.0)
3.САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Гаргасан хувьцаат капитал		1,000,000.0
Гаргасан өрийн бичиг	1,743,000.0	
Өрийн бичгийн эргэн төлөлт	(25,000.0)	
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	3,606,936.1	2,954,915.0
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эргэн төлөлт	(1,843,741.8)	(3,776,767.0)
Төлсөн ногдол ашиг	(22,860.0)	
Ханшийн зөрүүний гарз	1,228.3	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,459,562.6	178,148.0
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	862,095.2	(404,015.0)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	233,179.0	637,194.0
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,095,274.2	233,179.0



Хүчтэй. Хамтдаа.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЦ

95.31%

Ард даатгал
Ердийн даатгал
1994

80.7%

Ард кредит
Банк бус санхүүгийн байгууллага
2011

100%

Ард Секюритиз
Үнэт цаасны компани
1997

9.55%

Жинс увс + Хөрөнгө оруулагч үндэстэн
Нээлттэй зах зээлийн ТЗК ХК
1992

100%

Ард лайф
Хувийн тэтгэвэрийн сан
2007

84%

Ард актив
Хадгаламж зээлийн хоршоо
2008

29.16%

Монгол шуудан
Шуудангийн цогц үйлчилгээ
1921

84%

Ард менежмент
Хөрөнгө оруулалтын зөвлөх
2011

100%

Ард Бит
Криптовалютын арилжаа, хэтэвч
2017

20%

Номын хишиг
Үл хөдлөх хөрөнгө
2000

100%

Тэнгэр системс
Мэдээллийн технологи
1997



ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД



Хүчтэй. Хамтдаа.